



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 218

Улаанбаатар хот

Шалгалтын удирдамж батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2 дахь заалт, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, Валютын зохицуулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хуулийн этгээдийн үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, хариуцан ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, шалгалтад хамрагдах байгууллагуудын нэрсийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газар /Н.Энхтуяа/-т даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2021 оны 9 дүгээр сарын 01-ны өдрийн 42 дугаар

тушаал хавсралт I



**ТӨЛБӨР ТООЦООГ ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТЭЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ
УДИРДАМЖ**

2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Шалгалтын зорилго нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд бараа, ажил, үйлчилгээ, зар сурталчилгааны үнэ, үнийн саналыг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж, төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр гүйцэтгэж буйд хяналт, шалгалт хийх, илэрсэн зөрчил, дутагдалд хариуцлага оногдуулах, зөрчил, дутагдлыг арилгуулахад чиглэгдсэн шаардлагатай арга хэмжээ авахад оршино.

1.2 Шалгалтыг 2021 оны 9 дүгээр сарын 02-ны өдрөөс 9 дүгээр сарын 09-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

1.3 Шалгалтыг хуулийн этгээдийн 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс хойшхи хугацааны санхүүгийн баримтууд, холбогдох шийдвэрт үндэслэн хийнэ.

1.4 Шалгалтын ажлын хэсэг шаардлагатай гэж үзсэн тохиолдолд дээр заасан хугацаанаас өмнөх хугацааны баримтыг шалгаж болно.

1.5 Шалгалтыг тушаалын хавсралтаар батлагдсан ажлын хэсэг хийж гүйцэтгэнэ.

1.6 Ажлын хэсгийн ахлагч нь шалгалтыг тогтоосон хугацаанд чанартай, үр дүнтэй явуулахад ажлын хэсгийг удирдан зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд шалгалтын явц, үр дүнгийн талаар холбогдох удирдах албан тушаалтанд танилцуулах үүрэг хүлээнэ.

1.7 Хорооны даргын 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаар тушаалын хавсралтад дурдагдаж, шалгалтад хамрагдсан хуулийн этгээд нь шалгалтын ажлын хэсгийг шалгалт хийх нөхцөл бололцоогоор бүрэн хангаж, шаардлагатай тайлан мэдээ, санхүүгийн баримт, холбогдох баримт бичгүүдийг шаардсан хугацаанд бэлэн байлгана.

Хоёр. Шалгах ажлын хүрээ

2.1 Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд бараа, ажил, үйлчилгээ, зар сурталчилгааны үнэ, үнийн саналыг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж, төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр гүйцэтгэх холбогдох хуулийн шаардлагыг хангаж буй эсэх;

2.2 Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоож, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр зар сурталчилгаа хийж буй эсэх;

2.3 Хуулийн этгээдийн үйлдвэрлэх, борлуулах бүтээгдэхүүн, хийж гүйцэтгэх болон гүйцэтгэсэн бүхий л төрлийн ажил, үйлчилгээний хөлс болон ажилчдад олгож буй цалин, түүнтэй адилтгах орлогыг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр гүйцэтгэх шаардлагыг хангаж буй эсэх;

2.4 Хуулийг хэрэгжүүлэхэд үүсэх сөрөг үр дагаварыг арилгах, зохиомлоор дотоодын үнийн өсөлтийг хөөрөгдөхгүй байх бизнесийн шударга ёс зүйг сахиж буй эсэх.


Гурав. Шалгалтын дүн гаргах, тайлагнах

3.1 Шалгалтын ажлын хэсгийн улсын байцаагчид валютын хяналтын улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж, илэрсэн зөрчил, дутагдал бүрт акт тогтоож, бүрэн эрхийн хүрээнд Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн дагуу захиргааны хариуцлагыг ногдуулж, зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч, шийдвэрлүүлнэ.

3.2 Шалгалтын ажлын хэсэг шалгалтын нэгдсэн тайланг шалгалт дууссанаас хойш ажлын 3 хоногийн дотор бичиж, шалгалтын тайлан, газар дээрх шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалд ногдуулсан захиргааны хариуцлагын талаар Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргад танилцуулна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2021 оны 9 дүгээр сарын 1-ны өдрийн 218 дугаар
тушаал хавсралт 2



ГАЗАР ДЭЭРХ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН,
ШАЛГАЛТАД ХАМРАГДАХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НЭР

Д/д	Байгууллагын нэрс	Хаяг, утас	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
1	“Ремон” ХХК	Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Үйлдвэрийн төвийн бүс, Тээвэрчдийн гудамж, WV центр, 10 дугаар давхар.	<i>Ахлагч:</i> ҮХХЗҮЭЗГ-ын ахлах хянан шалгагч, валютын улсын байцаагч Э.Норовцэрэн <i>Гишүүн:</i> ҮХХЗҮЭЗГ-ын мэргэжилтэн Ч.Сосорбарам ҮХХЗҮЭЗГ-ын мэргэжилтэн Н.Энх-Амгалан